

## ТАНИЛЦУУЛГА

*Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл ("К")-ийг тогтоох тухай Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын төсөл боловсруулсан тухай*

2024.11.25

Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтыг үндэслэн 2014, 2017, 2019, 2021 онуудад, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ын 8 дугаар зүйлийн 8.3 дахь заалтыг үндэслэн 2023 онд тус тус баталсан.

Хүснэгт 1

Хүйс	Он									
	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024
Эмэгтэй	22 жил 6 сар	22 жил 6 сар	22 жил 6 сар	22 жил 6 сар	22 жил 6 сар	22 жил 6 сар	22 жил 6 сар	22 жил 6 сар	22 жил 6 сар	22 жил 6 сар
Эрэгтэй	-	-	-	-	-	15 жил 6 сар	15 жил 6 сар	15 жил 6 сар	15 жил 6 сар	15 жил 6 сар

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу өндөр насны тэтгэврийн хэмжээг нэрийн дансны аргаар бодохдоо тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл ("К")-ийг ашиглахаар баталсан.

Нийгмийн даатгалын санд 2013 оноос хойш бүртгэгдсэн даатгуулагч, тэтгэвэр авагчид, нас барсан даатгуулагч, тэтгэвэр авагчдыг мэдээлэл дээр үндэслэн тооцоолол хийсэн.


Хүснэгт 2

Он	Эм /55-аас дээш нас/				
	Дундаж нас	Дундаж нас баралт	Тооцоолсон нас	Амьдрах хугацааны илэрхийлэл	
2013	65.0	67.8		77.5	
2014	64.8	71.1		77.5	
2015	64.5	71.2		77.5	
2016	64.5	71.7		77.5	
2017	64.4	72.0		77.5	
2018	64.4	72.7		77.5	
2019	64.4	72.7		77.5	
2020	64.5	73.2		77.5	
2021	64.5	74.2		77.5	
2022	64.6	74.3		77.0	
2023				71.3	77.0
2024				71.3	77.0
2025				71.5	77.0
2026			71.6	77.0	



Хүснэгт 3

Он	Эр /60-аас дээш нас/			
	Дундаж нас	Дундаж нас баралт	Тооцоолсон нас	Амьдрах хугацааны илэрхийлэл
	68.6	69.1		
2014	68.5	70.6		
2015	68.4	71.1		
2016	68.2	71.1		
2017	68.1	71.2		
2018	67.9	71.0		
2019	67.8	71.4		
2020	67.7	71.6		75.5
2021	67.6	72.2		75.5
2022	67.6	71.5		75
2023			70.4	75
2024			70.5	75
2025			70.6	75
2026			70.8	75



Дээрх тооцоолол (хүснэгт 2, 3)-оос харахад 55 нас хүрсэн эмэгтэйчүүдийн дундаж нас 71.6 буюу дундаж наслалт 16.6, 60 нас хүрсэн эрэгтэйчүүдийн дундаж нас 70.8 буюу дундаж наслалт 10.8 байна.

Үндэсний статистикийн хороо 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 01/945 дугаартай албан бичгээр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын төсөлд тусгайлан өгөх саналгүй гэсэн хариуг ирүүлсэн.

Дээрх тооцоолол, санал, 2024 онд мөрдөж байгаа тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг харгалзан үзэж, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.3-д заасны дагуу тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл ("K")-ийг 2025, 2026 онд эмэгтэй даатгуулагч 22 жил, эрэгтэй даатгуулагч 15 жил байх тогтоолын төсөл боловсруулсан.

--- о О о ---

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ  
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны ... сарын .... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тэтгэвэр авах дундаж хугацааны  
илэрхийлэл тогтоох тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу нэрийн дансны аргаар өндөр насны тэтгэвэр тогтоолгоход баримтлах тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл ("К")-ийг 2025, 2026 онд эмэгтэй даатгуулагчид 22 жил, эрэгтэй даатгуулагчид 15 жилээр тус тус тогтоож мөрдсүгэй.

2. Энэ тогтоолоор баталсан тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу нэрийн дансны аргаар өндөр насны тэтгэвэр бодоход баримталж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Ц.Ганцэцэг)-т даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба (Г.Банзрагч) -нд үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

Гарын үсэг